| 11 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **2,195,437,439.13** | **1,664,969,411.90** | **931,288,541.82** | **4,791,695,392.85** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | **0.00** | **0.00** | **17,798.00** | **17,798.00** |
| 13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,195,437,439.13** | **1,664,969,411.90** | **931,306,339.82** | **4,791,713,190.85** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | -17,798.00 | 0.00 | -17,798.00 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 19 | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **311,933,539.72** | **311,933,539.72** |
| 20 | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **2,195,437,439.13** | **1,664,951,613.90** | **1,243,239,879.54** | **5,103,628,932.57** |

## 2.5. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,234,305,600.00** | **2,029,789,466.17** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,973,081,000.00** | **1,909,645,726.17** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,919,473,500.00** | **1,857,535,623.17** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,270,634,200.00** | **1,236,766,031.48** |
| 210101 | Үндсэн цалин | 998,903,500.00 | 973,450,338.21 |
| 210102 | Нэмэгдэл | 125,537,100.00 | 129,253,587.39 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,808,000.00 | 4,658,000.00 |
| 210104 | Урамшуулал | 80,799,700.00 | 77,424,479.88 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 59,585,900.00 | 51,979,626.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **171,535,400.00** | **162,089,673.10** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 120,710,200.00 | 113,694,539.45 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,706,300.00 | 12,548,193.72 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,165,000.00 | 10,005,869.85 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,541,300.00 | 2,349,022.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,412,600.00 | 23,492,047.15 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **218,749,100.00** | **215,279,449.59** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,119,100.00 | 9,819,521.59 |
| 210302 | Түлш, халаалт | 197,554,000.00 | 202,251,028.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,076,000.00 | 3,208,900.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **83,323,300.00** | **82,362,240.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,031,400.00 | 6,223,610.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 45,031,200.00 | 44,535,380.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,070,600.00 | 3,873,200.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 555,500.00 | 525,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 6,939,200.00 | 6,647,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 20,695,400.00 | 20,557,550.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **79,269,600.00** | **75,146,731.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 26,205,100.00 | 26,204,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 47,506,300.00 | 43,396,531.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,558,200.00 | 5,545,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **33,950,400.00** | **29,966,900.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,283,700.00 | 14,283,700.00 |
| 210602 | Тавилга | 1,880,000.00 | 1,876,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,583,300.00 | 2,583,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,203,400.00 | 11,223,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **8,325,400.00** | **5,485,300.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,325,400.00 | 5,485,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,282,000.00** | **7,898,198.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,267,400.00 | 3,546,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,886,400.00 | 1,625,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 270,500.00 | 227,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 255,100.00 | 199,071.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 135,000.00 | 88,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,377,600.00 | 2,128,370.00 |
| 210807 | Газрын төлбөр | 90,000.00 | 83,657.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **44,404,100.00** | **42,541,100.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 37,989,800.00 | 36,156,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,414,300.00 | 6,384,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **53,607,500.00** | **52,110,103.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **53,607,500.00** | **52,110,103.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 40,605,400.00 | 40,379,403.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,002,100.00 | 11,730,700.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **161,224,600.00** | **120,143,740.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | 161,224,600.00 | 120,143,740.00 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **100,000,000.00** | **0.00** |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 100,000,000.00 | 0.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,234,305,600.00** | **2,134,179,930.17** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,322,157,300.00** | **1,315,552,902.94** |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,205,334,300.00 | 1,198,729,948.94 |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 116,823,000.00 | 116,822,954.00 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **748,481,700.00** | **702,618,350.23** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 748,481,700.00 | 702,618,350.23 |
| **33** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **18,545,000.00** | **18,689,990.00** |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 18,545,000.00 | 18,689,990.00 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **145,121,600.00** | **97,318,687.00** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 90,720,000.00 | 97,318,687.00 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 31,401,600.00 | 0.00 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 23,000,000.00 | 0.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 25,711,849.94 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 130,102,313.94 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **655.00** | **655.00** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **6.00** | **6.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 6.00 | 6.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **107.00** | **107.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 12.00 | 12.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 63.00 | 63.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 21.00 | 21.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 11.00 | 11.00 |

## 2.6. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **288,429,544.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **129,941,142.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **99,275,142.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **27,430,505.00** |
| 210101 | Үндсэн цалин | 27,430,505.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **3,449,375.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,373,192.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 269,045.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 215,233.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 53,808.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 538,097.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **2,926,778.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 143,678.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 199,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 214,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 530,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,840,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **39,608,020.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 31,387,250.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,982,370.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,238,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **17,358,800.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,250,000.00 |
| 210602 | Тавилга | 500,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 7,510,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,098,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **8,501,664.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,056,664.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,445,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **30,666,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **30,666,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 30,666,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **158,488,402.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **158,488,402.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | 158,488,402.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **288,429,544.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **288,429,544.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 165,663,744.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 122,765,800.00 |

## 3 Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Завхан сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Нанжидмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Завхан сумын Засаг даргын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Шалгагдагч этгээд, түүний орчин ба дотоод хяналт

Завхан сумын Засаг дарга нь “Оновчтой бодлого зохицуулалтаар ард иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлж, орон нутгаа хөгжүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн салбарыг эрчимжүүлэн хөгжүүлэх
- Байгаль хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх
- Орон нутагт дэд бүтэц, бизнесийн орчныг сайжруулах
- Байгалийн баялаг, орон нутгийн нөөц боломжид тулгуурлан жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх
- Төрийн үйлчилгээний ил тод байдлыг ханган чанар хүртээмжийг дээшлүүлэх
- Төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

Шалгагдагч этгээдийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Завхан сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан сумын Засаг даргын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 30.7 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,069.6 сая төгрөгийн 1 хувь буюу 30.7 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 24.5 сая төгрөгөөр тогтоолоо.
Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Завхан сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,136.4 сая төгрөгөөр буюу 18.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал , үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая. төгрөгөөр /

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | **491.40** | **634.90** | 143.50 |
| Мөнгөн хөрөнгө | **74.90** | **207.90** | 133.00 |
| Авлага | **208.50** | **206.60** | -1.90 |
| Бараа материал | **207.70** | **220.40** | 12.70 |
| Үндсэн хөрөнгө | **4,306.70** | **4,479.30** | 172.60 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **4,797.90** | **5,114.20** | 316.30 |
| Өр төлбөр | **6.20** | **10.60** | 4.40 |
| Засгийн газрын хувь оролцоо | **4,791.70** | **5,103.60** | 311.90 |
| **Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **4,797.90** | **5,114.20** | 316.30 |

*Эх сурвалж: Завхан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 207.9 сая төгрөг болж 133.0 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлого, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эрүүл мэндийн төвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 206.6 сая төгрөг болж 1.9 сая төгрөгөөр буурсан нь сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага буурснаас шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

***Завхан сумын Ерөнхий боловсролын сургууль:***

*Боловсрол, шинжлэх ухааны яамны "Боловсрол чанарын шинэчлэл" төслийн хүрээнд хийгдээгүй ажлын санхүүжилт 1,876.0 мянган төгрөгийг нярвын дансанд шилжүүлснийг санхүүгийн тайланд авлага тусгуулан залруулга хийлгэв*

***Завхан сумын Эрүүл мэндийн төв:***

*Ундарга-Увс ХХК-аас авах 2,345.7 мянган төгрөгийн авлагыг бараа материалын тодруулга тайланд түлш шатах тослох материалын үлдэгдлээр тайлагнасныг залрууллаа.*

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 220.4 сая төгрөг болж 12.7 сая төгрөгөөр өссөн нь Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,479.3 сая төгрөг болж 172.6 сая төгрөгөөр өссөн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 99.3 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 348.0 сая, нийт 447.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 55.9 сая төгрөгийн хөрөнгө акталж хассанаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,103.6 сая төгрөг болж 311.9 сая төгрөгөөр буюу 6.5 хувиар өссөн байна

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 515.9 сая төгрөгөөр буюу 16.8 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 209.7 сая төгрөгөөр буюу 7.3 хувиар өссөн байна.

### 3.5.5 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 76.0 сая, татварын бус орлого 403.4 сая, тусламж санхүүжилтийн орлого 3,105.6 сая, нийт 3,585.0 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

### 3.5.6 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчид 28.7 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

***Завхан сумын Засаг даргын тамгын газар :***

*-Засаг даргын нөөц хөрөнгөөс шашны үйл ажиллагаанд 1.3 сая, албан томилолтоор ажилласан төрийн албан хаагчдын хоолны зардалд 0.4 сая, нийт 1.7 сая төгрөгийг зарцуулж төрд хохирол учруулсан зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.*

*-Засаг даргын нөөц хөрөнгөөс дууны клип бүтээх зардалд 0.3 сая, бэлэг дурсгалд 0.6 сая , төрийн бус байгууллагын шагналд 0.4 сая, нийт 1.3 сая төгрөгийн зарцуулсанд зөрчилд Засгийн газрын 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.*

***Завхан сумын Эрүүл мэндийн төв:***

*Нэг удаагийн тэтгэмж урамшууллын 8.4 сая төгрөгийн зардлыг цалингийн зардалд тайлагнасныг залруулаа.*

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Завхан сумын 2021 оны төсвийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 2/07 дугаар тогтоолоор 2,184.3 сая төгрөгөөр баталж 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 4/02 дугаар тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 50.0 сая төгрөгөөр өсгөж 2,234.3 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,234.3 сая төгрөгийн төсөв баталснаас 1,322.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 748.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 18.5 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 145.1 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас, санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,315.5 сая, орон нутгийн төсвөөс 702.6 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 18.6 сая, төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 97.3 сая, нийт 2,134.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,909.6 сая төгрөгийг зарцуулж улсын төсөвт 6.6 сая, орон нутгийн төсөвт 46.5 сая, нийт 53.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,029.8 сая төгрөг буюу 90.1 хувьтай байгаа нь харилцах дансны үлдэгдэл 130.1 сая, зардлын хэмнэлт 53.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь нөлөөлсөн байна.

Завхан сумын ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн сумын 2021 оны тодотгосон төсөв батлах тухай 04/02 дугаар тогтоолд зааснаар Завхан сумын Засаг дарга тайлант онд 52.3 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 83.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 159.5 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 165.6 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 122.7 сая, нийт 288.4 төгрөгийн орлогыг бүрдүүлж 288.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

**3.8 Аудитын гол асуудал**

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

**3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Завхан сумын Засаг даргын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх аудитаар илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 154, хугацаа хоцроож 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Эрүүл мэндийн төвийн Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогын авлага 57.1 сая төгрөг байна. Тухайн авлагын дагуу 2022 оны 1 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна.

Засаг даргын тамгын газар нь Аймгийн Засаг даргын 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн А/43 дугаар захирамжаар сумдын Засаг даргын тамгын газрын, багийн бүтэц орон тоог батлахдаа гэрээт ажилтны орон тоог батлаагүй байна.

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

### 3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Завхан сумын Засаг даргын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 санг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 5 байгууллагын санхүүгийн тайланд "Зөрчилгүй", 1 байгууллагын санхүүгийн тайланд "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 15.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 10.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 1.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1.3 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Засаг даргын тамгын газар | 2 | 3.0 | 0 | 0 | 1 | 1.7 | 0 | 0 | 1 | 1.3 |
| 2 | Эрүүл мэндийн төв | 2 | 10.7 | 2 | 10.7 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 3 | Ерөнхий боловсролын сургууль | 1 | 1.8 | 1 | 1.8 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 4 | Соёлын төв | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 5 | Цэцэрлэг | | | | | | | | | | |
| 6 | ИТХ | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 7 | **Нийт** | **5** | **15.5** | **3** | **12.5** | **1** | **1.7** | **0** | **0** | **1** | **1.3** |

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

/сая төгрөгөөр/

| № | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Завхан сумын Засаг дарга | 0 | 0.0 | | | | | | | | |
| | **НИЙТ** | **0** | **0.0** | | | | | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /А.НАНЖИДМАА/

2022 оны 03 сарын 24-ний өдөр